

653

**МОНГОЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ХОРШООЛЫН ТӨВ
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ ХОРОО, УЛААНБААТАР
ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
Т О Г Т О О Л**

1990 оны 10 дугаар
сарын 04-ны өдөр

Дугаар 04/227

Улаанбаатар
хот

**Улаанбаатар хотод малын зах
байгуулах тухай**

"Малын зах зохион байгуулах тухай" БИМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 425 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хэрэглээний хоршоолын төв холбооны ерөнхий хороо, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, улс хоршооллын байгууллага, ард иргэдээс мал, гэрийн тэжээвэр амьтдыг худалдах байнгын ажиллагаатай малын захыг хотын Хүнсний захын харъяанд 1990 оны 10 дугаар сарын 13-наас байгуулан аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулсугай.

Малын захын ажиллагааны түр журмыг хавсралтаар зөвшөөрсүгэй.

2. Малын бэлчээр, ус, тууврын зам, зорчигч тээврийн үйлчилгээний боломжийг харгалзан Буянт-Ухаад байгаа Ажилчны районы өвсний сангийн болон Гутлын үйлдвэр, Савжин эдлэлийн үйлдвэрүүдийн аж ахуйн хашаа байгаа 4,5 га талбай эдэлбэр газрыг малын захад шилжүүлэн олгож, Ажилчны дүүргийн өвсний сангийн хашаа, барилгыг хотын хүнсний захын захиргаанд балансаас балансад 1990 оны 10 дугаар сарын 5-наар тасалбар болгон шилжүүлэхийг Ажилчны районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /Н.ОЙДОВСАМБУУ/-д даалгасугай.

3. 1990 онд багтаан Багануур, Налайхын хүнсний захыг мал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах болгон өргөтгөж, дотоод нөөц бололцоогоо ашиглан Лун, Багахангай хороонд хүнсний зах зохион байгуулж ажиллахыг эдгээр район, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

4. Малын захын дэргэд мал нядлах, гэдэс арилгах, мах эвдэх, арьс давслах зэрэг үүрэг бүхий ажлын байр бий болгон төлбөрт

үйлчилгээний хэлбэрээр ажиллуулахыг хотын хүнсний зах /н.ШИРЧИН/-д даалгасугай.

5. Малын зах ажиллах өдрүүдэд зохицуулагч, сэргийлэгч нарыг байнга ажиллуулж авто техникийн аюулгүй байдлыг хангах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Авто техникийн хэргийг шалган байцаах газрын хотын хөдөлгөөний алба /н.САЯБОЛД/, Хотын цагдан сэргийлэх газар /н.ГАРАВСҮРЭН/-т даалгасугай.

6. Малын зах дээр худалдаж байгаа хүнсний хэрэгцээний болон үржлийн мал, амьтад, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийж байнгын хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах ажиллахыг хотын мал эмнэлгийн газар /н.БҮРТЭДЭЭ/-т даалгасугай.

7. Малын захад байгууллага, ард иргэдээс худалдахаар авч ирсэн мал, амьтадад болон түүний эзний талаар гөдөрхөй бүртгэл хөтлөн худалдагдсаг малаас гарах арьс, шир, ноос түүхий эдийг бүрэн цуглуулж авах ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар хотын хүнсний захын захиргаа /н.ШИРЧИН/, Хотын бэлтгэлийн контор /н.СОДНОМЦОГ/-т үүрэг болгосугай.

8. Малын захад дэвсгэрийн мал бүхий байгууллага, ард иргэдээс өөрийн хэрэгцээнээс илүү байгаа мал, амьтад худалдах ажлыг сурталчлан зохион байгуулж, иргэдээс захад худалдах байгаа мал амьтад байнгын хяналт тавьж байхыг район, хорооны АДХ-ни гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

9. Малын захын дэргэд нийтийн хоолны гуанз, хүнс, аж үйлдвэрийн барааны мухлаг байгуулан ажиллуулахыг Нийтийн хоолны үйлдвэрлэлийн нэгдэл /н.ВАНДАНДОРЖ/, Хүнсний бараа худалдааны нэгдэл /н.БАДАРЧ/, Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл /н.МИНИЦОРЖ/ нарт даалгасугай.

10. Малын захын үйл ажиллагаатай холбоотой бүртгэл, мэдээ, тайлангийн асуудлыг боловсруулан мөрдөхийг Нийгэм, эдийн засгийн хөгжлийн газар /н.БАТ/, Хүнсний захын захиргаа /н.ШИРЧИН/ нарт даалгасугай.

11. Нийслэлийн хөдөлмөрчдийн захиалгыг үндэслэн үржлийн мал, амьтадыг хөдөө орон нутгаас ирүүлж малын захад худалдуулан ард иргэдийн амины мал амьтадын үүлдэр, ашиг шимийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Хотын хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийг удирдах газар /н.МИШИДЦОРЖ/-д даалгасугай.

12. Хотын малын захын нээлтэд болон цаашид орон нутгийн хэрэглээний хоршоо, иргэдээс мал эмнэлгийн шинжилгээ бүхий өргүүл, тарга хүч сайтай малыг зохин байгуулалттайгаар ирүүлэн худалдааж байхыг Монголын хэрэглээний хоршоодын төв холбооны улсын бэлтгэлийн хэлтэс /н.МАНАЛЖАВ/-т үүрэг болгосугай.

МОНГОЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ХОРШООДЫН
ТӨВ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ ХОРООНУ
ДАРГА

УЛААНБААТАР ХОТЫН АХУ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

Ч.Молон Ч.МОЛОН



Д.Энэмш Д.ЭНЭМШ



Монголын хэрэглээний хөршөөдми төв хол-
бооны эрэнхий хороо, Улаанбаатар хотын
АДХ-ийн гүйцэтгэх захиргааны 1980 оны
дугаар тогтоолоор зөвшөөрөв.

МАЛЫН ЗАХЫН АЖИЛААГААНЫ ТҮР ХУРАМ

Нийслэл хотын малын зах дээр үржлийн болон хүнсний хэрэг-
лээний тарга хүч сайтай мал амьтадыг тохиролцооны үнээр худал-
даалан хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд энэхүү түр хур-
мын зорилго оршино.

1. Малын захад худалдах малыг хотын хүнсний замаас хөдөө
орон нутгаас гэрээлэн ирүүлэх буюу аймаг, сумын хэрэглээний хор-
шоод мал бүхий аж ахуй, үйлдвэр, албан байгууллага, ард иргэдээс
тохиролцооны үнээр худалдан авч хотын малын захад худалдаална.
Мөн Улаанбаатар хотын район, хороодны АДХ-ийн гүйцэтгэх захиргаа
зохион байгуулан дэвсгэрийнхээ мал бүхий байгууллага, ард иргэ-
дийг чөлөөтэй оролцуулж байна.

2. Малын захыг ажлын хашаа, байраар хангах, талбэрт үйлчилгээ-
ний цэг нээх зэрэгт шаардагдах зардал, орон тоо, ажиллах хүч болон
малыг өвс тэжээлээр хангах үүргийг Улаанбаатар хотын хүнсний за-
хын захиргаа хүлээнэ.

3. Худалдах малын хашааг малын төрөл, аймаг, сумдаар болон
үнээр нь ялгавартай байрлуулахаар зохион байгуулж, худалдан авагч
еерөө сонгож авах боломжийг бүрдүүлнэ.

4. Худалдах мал, гахай, шувуу нь эртэл нутгаас бэлтгэгдсэн
байх ёстой. Энэ талаар мал эмнэлэг, ариун цэврийн байгууллагын
магадлагаатай байна.

5. Худалдаалах малын үнийг худалдагч, худалдан авагчид хоорон-
доо тохиролцоно.

6. Зах дээр мал, амьтад худалдан борлуулах иргэд, байгууллага
тогтоосон тариф, журмы дагуу Хүнсний захын захиргаанд зөхих хэм-
жээний хураамж төлнэ.

7. Захын захиргаа мал худалдах, худалдан авах иргэд, байгуул-
лагын унаа, байр сууцыг байрлуулах талбай гаргах захын хашаанд
оруулах дарааллыг тогтоосон журамлана.

8. Мал худалдан авах иргэд нь иргэний паспорт, ажлын газрын үнэмлэхийг холбогдох хүмүүст шалгуулж зөвшөөрөл авсны дараа захын хашаанд орох эрхийн бичиг авна.

9. Мал худалдаж дууссаны дараа тухайн байгууллага иргэд эзэмисэн хашаа, талбайгаа цэвэрлэж захын захиргаанд хүлээлгэн өгч эцсийн тооцоо хийнэ.

10. Захын хашаанд нэг удаа оруулсан хэсэг малыг худалдаж дуусаад дараагийн ээлжийн малыг залгуулан оруулахад зохих бэлтгэлийг хангах хүртэл хугацаанд мал худалдан авах хүмүүсийг захын хашаанд оруулахгүй.

11. Захын хашааны гадна мал худалдахыг болон нэгэнт захаас худалдан авсан малыг дахин дамлан худалдаалахыг хориглоно. Үүнийг зөрчсөн нөхцөлд торгууль ноогдуулах асуудлыг Хүнсний захын захиргаа, хууль хяналтын байгууллагын зохих албаны хүмүүс гүйцэтгэнэ.

12. Мал худалдах албан байгууллага, иргэд 7 хоногийн өмнө худалдах малынхаа төрөл, тоо, нас хүйсийг Хүнсний захын захиргаа 20289 номерийн утсанд өгч дараалал авсан байх ба малын захад ирээд худалдах малын нас, хүйс, зүс, содон тэмдгээр бүртгүүлж малын эзэн оршин суудаг хаяг, ажлын газар, паспортын дугаараа заавал бүртгүүлж зөвшөөрөл авна.